





НИЙСЛЭЛИЙН БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ 2020-2023



СУРГУУЛЬ

ЦЭЦЭРЛЭГ

ЦЭЦЭРЛЭГ



АГУУЛГА



БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ 2020-2023 ОН

ЦЭЦЭРЛЭГ	2
СУРГУУЛЬ	3
БАРИЛГА БҮТЭЭН БАЙГУУЛАЛТУУД	4



БОЛОВСРОЛЫН САЛБАРТ 2020-2023 ОНД ХЭРЭГЖСЭН НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

НИЙТ	5
ОНООР	5
ХӨРӨНГИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭР	5
ДҮҮРГЭЭР	6
АЖЛЫН ҮНДСЭН ТӨРЛӨӨР	6
АЖЛЫН БАЙРНЫ ТОО	7



БАРИЛГА УГСРАЛТ

СУРГУУЛИЙН БАРИЛГА	8-10
ЦЭЦЭРЛЭГИЙН БАРИЛГА	11-13
БАГА СУРГУУЛЬ ЦЭЦЭРЛЭГИЙН ЦОГЦОЛБОР	14
БУСАД БАРИЛГА БАЙГУУЛАМЖ	15



ИХ ЗАСВАР

СУРГУУЛИЙН ЗАСВАР	16-17
ЦЭЦЭРЛЭГИЙН ЗАСВАР	18-19



ТОХИЖИЛТ

СУРГУУЛИЙН ТОХИЖИЛТ	20-21
ЦЭЦЭРЛЭГИЙН ТОХИЖИЛТ	22-23



ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

СУРГУУЛИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ	24
ЦЭЦЭРЛЭГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ	25



ДҮҮРГЭЭР

БАЯНГОЛ	26-28
БАЯНЗҮРХ	29-31
СҮХБААТАР	32-34
СОНГИНОХАЙРХАН	35-37
ХАН-УУЛ	38-40
ЧИНГЭЛТЭЙ	41-43
НАЛАЙХ	44-46
БАГАНУУР	47-49
БАГАХАНГАЙ	50-52



ХАВСРАЛТ

2020-2023 ОНД АШИГЛАЛТАД ОРУУЛСАН СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГИЙН БАРИЛГА	53-61
2024 ОНД АШИГЛАЛТАД ОРУУЛСАН СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГИЙН БАРИЛГА	62-63
2024 ОНД ХЭРЭГЖИЖ БҮЙ БАРИЛГА УГСРАЛТЫН АЖИЛ	64-68

ӨМНӨХ ҮГ



Нийслэлийн боловсролын салбарт хэрэгжиж дууссан болон хэрэгжиж буй хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээний нэгдсэн мэдээллийн санг бий болгож, үнэлж дүгнэх, мэдээллийг ил тод болгох, цаашдын хөрөнгө оруулалтын төлөвлөлт, удирдлагыг оновчтой болгох үүднээс Нийслэлийн хөрөнгө оруулалтын газраас энэхүү эмхэтгэлийг 4 жил тутам буюу 2 дахь удаа гарган танилцуулж байна.

2020-2023 онд нийслэлийн боловсролын салбарт бүрэн хийгдэж дууссан, 2024 онд хэрэгжиж буй нийт хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажлын мэдээллийг иргэд, судлаач, иргэний нийгмийн байгууллагууд, төрийн албан хаагчдад ойлгомжтой хэлбэрээр бэлтгэн боловсрууллаа.

Тухайлбал, 2020-2023 онд нийслэлийн хэмжээнд шинээр нийт 36 сургууль, 109 цэцэрлэг, 8 бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор барилгыг бүрэн ашиглалтад оруулсан бөгөөд 2024 онд 36 сургууль, 58 цэцэрлэг, 18 бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор барилгын бүтээн байгуулалтын ажлууд хийгдэж

байгаа нь өмнөх дөрвөн жилтэй (2016-2019 он) харьцуулахад боловсролын салбарын хөрөнгө оруулалт нь 56 хувиар өссөн дүнтэй байна.

Мөн 122 сургууль, 125 цэцэрлэгт засвар, тохижилтын ажил, 58 сургууль, 210 цэцэрлэгт тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтын ажил хийгдэж, сурч боловсрох орчин нөхцөлийг сайжруулсан байна.

Энэхүү тайлангаас нийслэлийн боловсролын салбарын хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын тоо, мэдээллийг хөрөнгийн эх үүсвэр, ажлын төрөл, дүүрэг, оноор нь харж болохоос гадна дүүрэг тус бүрд хийгдсэн боловсролын салбарын хөрөнгө оруулалтын дэлгэрэнгүй мэдээллийг авах боломжтой юм.


НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА

Б.МӨНХБАТ

БҮЛЭГ 1. БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ 2020-2023 ОН

1.1 ЦЭЦЭРЛЭГ

НИЙТ ЦЭЦЭРЛЭГИЙН ТОО



МУ-ЫН ХЭМЖЭЭНД

2020	1454
2021	1453
2022	1413
2023	1410

НИЙСЛЭЛД

701
694
666
676



ЦЭЦЭРЛЭГТ ХАМРАГДСАН ХҮҮХДИЙН ТОО



МУ-ЫН ХЭМЖЭЭНД

2020	247,040
2021	190,991
2022	266,024
2023	274,236

НИЙСЛЭЛД

109,376
83,658
125,154
130,092



ЦЭЦЭРЛЭГИЙН ҮНДСЭН БАГШИЙН ТОО



МУ-ЫН ХЭМЖЭЭНД

2020	8,827
2021	8,824
2022	9,450
2023	9,733

НИЙСЛЭЛД


4,074
4,017
4,584
4,762

1.2 СУРГУУЛЬ



ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН НИЙТ СУРГУУЛИЙН ТОО

	МУ-ЫН ХЭМЖЭЭНД	НИЙСЛЭЛД
2020	839	276
2021	848	285
2022	859	297
2023	871	306



ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРАГЧДЫН ТОО

	МУ-ЫН ХЭМЖЭЭНД	НИЙСЛЭЛД
2020	680,837	317,978
2021	712,368	340,146
2022	746,405	364,488
2023	771,722	381,779



ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ҮНДСЭН БАГШИЙН ТОО

	МУ-ЫН ХЭМЖЭЭНД	НИЙСЛЭЛД
2020	34,256	14,897
2021	35,110	15,406
2022	36,118	16,023
2023	36,993	16,724



1.3 БОЛОВСРОЛЫН САЛБАРТ 2020-2023 ОНД
БАРИГДСАН БАРИЛГА БҮТЭЭН БАЙГУУЛАЛТУУД

УЛСЫН ХЭМЖЭЭНД

НИЙТ
СУРГУУЛИЙН
ТОО

135

Он	ТОО	Суудал
2020	43	20980
2021	22	8420
2022	39	21498
2023	31	11860

НИЙТ
ЦЭЦЭРЛЭГИЙН
ТОО

209

Он	ТОО	Ор
2020	57	7635
2021	42	6175
2022	59	8995
2023	51	5640

БАГА СУРГУУЛЬ,
ЦЭЦЭРЛЭГИЙН
ЦОГЦОЛБОР
БАРИЛГЫН
ТОО

8

Он	ТОО	Суудал, Ор
2020	1	960
2021	2	460
2022	2	580
2023	3	860

НИЙСЛЭЛД

НИЙТ
СУРГУУЛИЙН
ТОО

36

Он	ТОО	Суудал
2020	10	6130
2021	9	5880
2022	5	3120
2023	12	7340

НИЙТ
ЦЭЦЭРЛЭГИЙН
ТОО

109

Он	ТОО	Ор
2020	28	4700
2021	23	4050
2022	26	3965
2023	32	4797



2020-2023 онд Нийслэлийн боловсролын салбарт 36 сургууль, 117 цэцэрлэг, 8 бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор барилгыг бүрэн ашиглалтанд оруулсан байна.

БҮЛЭГ 2. НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ


НИЙТ

2020-2023 онд Нийслэлийн боловсролын салбарт нийт **561.0** тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй **840** төсөл арга хэмжээ, хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажил хийгдсэн байна.



ОНООР

АЖЛЫН ТОО




Нийслэлийн боловсролын салбарт хийгдсэн нийт хөрөнгө оруулалтын ажлын тоог хэрэгжсэн оноор нь авч үзвэл:

2020 онд **130** ажил **146.2** тэрбум төгрөгөөр,
2021 онд **99** ажил **121.3** тэрбум төгрөгөөр,
2022 онд **252** ажил **111.1** тэрбум төгрөгөөр,
2023 онд **359** ажил **182.4** тэрбум төгрөгөөр тус тус хийгдсэн байна.

ХӨРӨНГИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭР

ТӨСӨВТ ӨРТГӨӨР




Нийт хийгдсэн хөрөнгө оруулалтыг төсөвт өртгийн эх үүсвэрээр нь авч үзвэл:

Улсын төсвийн хөрөнгөөр **57%** буюу 320.5 тэрбум төгрөгөөр **186** ажил, Нийслэлийн төсвийн хөрөнгөөр **15%** буюу 83.5 тэрбум төгрөгөөр **497** ажил, Дүүргийн хөрөнгөөр **1%** буюу 3.4 тэрбум төгрөгөөр **3** ажил, Гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр **23%** буюу 132.6 тэрбум төгрөгөөр **32** ажил, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр **1%** буюу 5.5 тэрбум төгрөгөөр **99** ажил,

НЗД нөөц хөрөнгөөр **3%** буюу 15.5 тэрбум төгрөгөөр **23** ажил тус тус хийгдсэн байна.

ДҮҮРГЭЭР



Нийт хийгдсэн хөрөнгө оруулалтыг дүүргээр авч үзвэл:



- Баянзүрх дүүрэгт **195** ажил **150.1** тэрбум төгрөгөөр,
- Сонгинохайрхан дүүрэгт **177** ажил **118.7** тэрбум төгрөгөөр,
- Хан-Уул дүүрэгт **152** ажил **105.8** тэрбум төгрөгөөр,
- Баянгол дүүрэгт **116** ажил **54.2** тэрбум төгрөгөөр,
- Чингэлтэй дүүрэгт **68** ажил **48.3** тэрбум төгрөгөөр,
- Сүхбаатар дүүрэгт **75** ажил **40.7** тэрбум төгрөгөөр,
- Налайх дүүрэгт **35** ажил **34.3** тэрбум төгрөгөөр,
- Багануур дүүрэгт **18** ажил **8.4** тэрбум төгрөгөөр,
- Багахангай дүүрэгт **4** ажил **0.6** тэрбум төгрөгөөр тус тус хэрэгжсэн байна.

АЖЛЫН ҮНДСЭН ТӨРЛӨӨР

Нийт хийгдсэн хөрөнгө оруулалтыг ажлын үндсэн төрлөөр авч үзвэл:

Барилга угсралтын ажилд **93%**,
Их засварын ажилд **4%**,
Тоног төхөөрөмж худалдан авах ажилд **2%**,
Тохижилтын ажилд **1%**-ийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна.



93%



4%



2%



1%

БАРИЛГА УГСРАЛТ

ТӨСӨВТ ӨРТӨГ
515.7
тэрбум.төг

АЖЛЫН ТОО
166

ИХ ЗАСВАР

ТӨСӨВТ ӨРТӨГ
24.9
ТЭРБУМ.ТӨГ

АЖЛЫН ТОО
186

ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

ТӨСӨВТ ӨРТӨГ
12.6
ТЭРБУМ.ТӨГ

АЖЛЫН ТОО
409

ТОХИЖИЛТ

ТӨСӨВТ ӨРТӨГ
7.9
ТЭРБУМ.ТӨГ

АЖЛЫН ТОО
79

2020-2023 ОНД НИЙСЛЭЛИЙН БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН АЖЛЫГ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН КОМПАНИЙН ТОО



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН
ГҮЙЦЭТГЭХЭД БИЙ БОЛСОН АЖЛЫН БАЙРНЫ ТОО

8400



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫГ АШИГЛАЛТАД
ОРУУЛСНЫ ДАРАА ШИНЭЭР БИЙ БОЛСОН АЖЛЫН БАЙРНЫ ТОО

4207



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮР АШИГ ХҮРТЭГСЭД /ДАВХАРДСАН ТООГООР/

	СУРАГЧ/ ХҮҮХЭД	БАГШ/ АЖИЛЧИД	НИЙТ
СУРГУУЛЬ	1.507.836	75.931	1.583.767
ЦЭЦЭРЛЭГ	376.783	33.753	410.536
НИЙТ	1.884.619	109.684	1.944.303



БҮЛЭГ 3. БАРИЛГА УГСРАЛТ

3.1 “СУРГУУЛИЙН БАРИЛГА”



2020-2023 онд шинээр нийт төрийн өмчийн 36 сургуулийн барилгыг 226.8 тэрбум төгрөгөөр барьж ашиглалтад оруулсан байна.

ТӨСӨЛ АРГА
ХЭМЖЭЭ


36

СУРГУУЛИЙН
БАРИЛГА

НИЙТ ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТ

226.8

ТЭРБУМ.ТӨГ



Нийт сургуулийн барилга угсралтын ажлыг хэрэгжсэн оноор нь авч үзвэл:

2020 онд **10** сургууль **70.6** тэрбум төгрөгөөр, 2021 онд **9** сургууль **57.9** тэрбум төгрөгөөр, 2022 онд **5** сургууль **23.7** тэрбум төгрөгөөр, 2023 онд **12** сургууль **74.6** тэрбум төгрөгөөр тус тус хийгдсэн байна.



Нийт сургуулийн барилга угсралтын ажилд хийгдсэн хөрөнгө оруулалтын төсөвт өртгийг эх үүсвэрээр нь авч үзвэл:

Улсын төсвийн хөрөнгөөр **51%** буюу **20** барилга **113.6** тэрбум төгрөгөөр,


Гадаадын зээл тусламж болон бусад хөрөнгөөр **44%** буюу **14** барилга **101.8** тэрбум төгрөгөөр,

Нийслэлийн төсвийн хөрөнгөөр **2%** буюу **1** барилга **5.1** тэрбум төгрөгөөр,


Нийслэлийн Засаг даргын нөөц хөрөнгөөр **3%** буюу **1** барилга **6.3** тэрбум төгрөгөөр хийгдсэн байна.

ДҮҮРГЭЭР

Сургуулийн
барилгын тоогоор



Төсөвт өртгөөр
/тэрбум.төг/



Шинээр баригдсан нийслэлийн төрийн өмчийн сургуулиудын барилга угсралтын ажлыг дүүргээр авч үзвэл:

Баянзүрх дүүрэгт **9** сургууль **52.6** тэрбум төгрөгөөр, Хан-Уул дүүрэгт **8** сургууль **54.7** тэрбум төгрөгөөр, Сонгинохайрхан дүүрэгт **8** сургууль **53.8** тэрбум төгрөгөөр, Баянгол дүүрэгт **5** сургууль **24.4** тэрбум төгрөгөөр, Сүхбаатар дүүрэгт **3** сургууль **15.8** тэрбум төгрөгөөр, Налайх дүүрэгт **2** сургууль **10.7** тэрбум төгрөгөөр, Чингэлтэй дүүрэгт **1** сургууль **14.7** тэрбум төгрөгөөр тус тус хэрэгжсэн байна.

ХОРООЛЛЫН
ХЭЛБЭРЭЭР

ШИНЭЭР БАРЬЖ АШИГЛАЛТАД
ОРУУЛСАН СУРГУУЛИЙН ТОО

36

ОРОН СУУЦНЫ
ХОРООЛОЛД



18

СУРГУУЛЬ

ГЭР
ХОРООЛОЛД



16

СУРГУУЛЬ

ХОЛИМОГ
ХОРООЛОЛД



2

СУРГУУЛЬ




ШИНЭЭР АШИГЛАЛТАД ОРСОН СУРГУУЛИЙН БАРИЛГА ХҮЧИН ЧАДЛААР

СУРГУУЛИЙН ШИНЭ
БАРИЛГА

480 суудал	1 сургууль
640 суудал	10 сургууль
720 суудал	1 сургууль
920 суудал	2 сургууль
960 суудал	4 сургууль
1200 суудал	1 сургууль

СУРГУУЛИЙН ӨРГӨТГӨЛИЙН
БАРИЛГА

320 суудал	8 сургууль
340 суудал	1 сургууль
450 суудал	1 сургууль
480 суудал	1 сургууль
640 суудал	5 сургууль
960 суудал	1 сургууль



2020-2023 онд нийслэлийн хэмжээнд нийт **14480** суудлын хүчин чадалтай **19** шинэ сургуулийн барилга болон нийт **7990** суудлын хүчин чадалтай **17** сургуулийн өргөтгөлийн барилгыг барьж ашиглалтад оруулсан байна.

ҮР ДҮН АЧ ХОЛБОГДОЛ

Сургуулийн барилга угсралт бүтээн байгуулалтын ажилд гүйцэтгэгчээр ажилласан компанийн тоо: **27**



Төрийн өмчийн сургуульгүй байсан хороодод барьсан сургуулийн тоо: **9**



Ажлын байрны тоо: **4989**
Барилга угсралтын үед **2710**
Ашиглалтад орсны дараа **2279**



Ачаалал хэтрэлтийг бууруулсан сургуулийн тоо: **17**



Улсад төлсөн татвар хураамж /ойролцоогоор/:
58.0 тэрбум.төг



Ашиглалтын шаардлага хангахгүй байсан сургуулиудыг буулгаж барьсан сургуулийн тоо: **2**



3.2 “ЦЭЦЭРЛЭГИЙН БАРИЛГА”



2020-2023 онд шинээр нийслэлийн төрийн өмчийн **109** цэцэрлэгийн барилгыг **225.7** тэрбум төгрөгөөр барьж ашиглалтанд оруулсан байна.

ТӨСӨЛ АРГА
ХЭМЖЭЭ


109

ЦЭЦЭРЛЭГИЙН
БАРИЛГА

НИЙТ ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТ

225.7


ТЭРБУМ.ТӨГ



Нийт цэцэрлэгийн барилга угсралтын ажлыг хэрэгжсэн оноор нь авч үзвэл :

2020 онд **28** цэцэрлэг **50.9** тэрбум төгрөгөөр, 2021 онд **23** цэцэрлэг **44.4** тэрбум төгрөгөөр, 2022 онд **26** цэцэрлэг **55.9** тэрбум төгрөгөөр, 2023 онд **32** цэцэрлэг **74.5** тэрбум төгрөгөөр тус тус хийгдсэн байна.

- Улсын төсвийн хөрөнгө
- Нийслэлийн төсвийн хөрөнгө
- Гадаадын зээл тусламж болон бусад хөрөнгө
- Нийслэлийн Засаг даргын нөөц хөрөнгө
- Дүүргийн хөрөнгө
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө



Цэцэрлэгийн барилга угсралтын ажлыг хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр нь авч үзвэл:

Улсын төсвийн хөрөнгөөр **61%** буюу **150.1** тэрбум төгрөгөөр **65** барилга,

Нийслэлийн төсвийн хөрөнгөөр **20%** буюу **52.8** тэрбум төгрөгөөр **33** барилга,



Гадаадын зээл тусламж болон бусад хөрөнгөөр **13%** буюу **30.2** тэрбум төгрөгөөр **13** барилга,

Нийслэлийн Засаг даргын нөөц хөрөнгөөр **4%** буюу **8.3** тэрбум төгрөгөөр **3** барилга,

Дүүргийн хөрөнгөөр **1%** буюу **3.2** тэрбум төгрөгөөр **2** барилга,

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр **1%** буюу **0.1** тэрбум төгрөгөөр **1** барилга тус тус хийгдсэн байна.

ДҮҮРГЭЭР


Цэцэрлэгийн
барилгын тоогоорТөсөвт өртгөөр
/тэрбум.төг/

Шинээр баригдсан нийслэлийн төрийн өмчийн цэцэрлэгүүдийн барилга угсралтын ажлыг дүүргээр авч үзвэл:

Баянзүрх дүүрэгт **33** цэцэрлэг **70.0** тэрбум төгрөгөөр, Сонгинохайрхан дүүрэгт **24** цэцэрлэг **45.3** тэрбум төгрөгөөр, Хан-Уул дүүрэгт **18** цэцэрлэг **39.2** тэрбум төгрөгөөр, Баянгол дүүрэгт **12** цэцэрлэг **25.1** тэрбум төгрөгөөр, Чингэлтэй дүүрэгт **9** цэцэрлэг **20.3** тэрбум төгрөгөөр, Сүхбаатар дүүрэгт **8** цэцэрлэг **18.3** тэрбум төгрөгөөр, Налайх дүүрэгт **4** цэцэрлэг **5.8** тэрбум төгрөгөөр, Багануур дүүрэгт **1** цэцэрлэг **1.7** тэрбум төгрөгөөр тус тус хэрэгжсэн байна.

ХОРООЛЛЫН
ХЭЛБЭРЭЭРШИНЭЭР БАРЬЖ АШИГЛАЛТАД
ОРУУЛСАН ЦЭЦЭРЛЭГИЙН ТОО

109

ОРОН СУУЦНЫ
ХОРООЛОЛД

64

ЦЭЦЭРЛЭГ

ГЭР
ХОРООЛОЛД

34


ЦЭЦЭРЛЭГ

ХОЛИМОГ
ХОРООЛОЛД

11

ЦЭЦЭРЛЭГ

ШИНЭЭР АШИГЛАЛТАД ОРСОН ЦЭЦЭРЛЭГИЙН БАРИЛГА ХҮЧИН ЧАДЛААР



ЦЭЦЭРЛЭГИЙН
ШИНЭ БАРИЛГА

25 ор	2 цэцэрлэг
32 ор	1 цэцэрлэг
50 ор	6 цэцэрлэг
75 ор	8 цэцэрлэг
100 ор	12 цэцэрлэг
150 ор	23 цэцэрлэг
200 ор	7 цэцэрлэг
240 ор	21 цэцэрлэг
250 ор	1 цэцэрлэг
280 ор	5 цэцэрлэг
300 ор	2 цэцэрлэг
320 ор	1 цэцэрлэг
360 ор	1 цэцэрлэг

ЦЭЦЭРЛЭГИЙН ӨРГӨТГӨЛИЙН
БАРИЛГА

30 ор	1 цэцэрлэг
50 ор	2 цэцэрлэг
100 ор	4 цэцэрлэг
150 ор	10 цэцэрлэг
240 ор	2 цэцэрлэг



2020-2023 онд нийслэлийн хэмжээнд нийт **15002** орны хүчин чадалтай **90** шинэ цэцэрлэгийн барилга болон **2510** орны хүчин чадалтай **19** цэцэрлэгийн өргөтгөлийн барилгыг барьж ашиглалтад оруулсан байна. Ингэснээр хүчин чадлыг **17512** ороор нэмэгдүүлсэн байна.

ҮР ДҮН АЧ ХОЛБОГДОЛ

Цэцэрлэгийн барилга угсралт бүтээн байгуулалтын ажилд гүйцэтгэгчээр ажилласан компанийн тоо: **93**



Төрийн өмчийн цэцэрлэггүй байсан хороодод барьсан цэцэрлэгийн тоо: **20**



Ажлын байрны тоо: **7618**
Барилга угсралтын үед: **5690**
Ашиглалтад орсны дараа: **1928**



Ачаалал хэтрэлтийг бууруулсан цэцэрлэгийн тоо: **19**



Улсад төлсөн татвар хураамж /ойролцоогоор/:
63.6 тэрбум.төг



Ашиглалтын шаардлага хангахгүй байсан цэцэрлэгүүдийг буулгаж барьсан цэцэрлэгийн тоо: **11**



3.3 “БАГА СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГИЙН ЦОГЦОЛБОР”



2020-2023 онд нийслэлийн хэмжээнд шинээр **2860** суудал/орны хүчин чадалтай **8** Цогцолборын барилгыг нийслэлийн төсвийн **40.2** тэрбум төгрөгөөр барьж 2016 онд ашиглалтад оруулсан байна. **6** цогцолбор барилгыг гэр хороололд, **2** цогцолбор барилгыг орон сууцны хороололд барьсан байна.

- БАГА НАСНЫ ЦЭЦЭРЛЭГ СУРГУУЛИЙН ХҮҮХДҮҮДИЙГ ХАМТАД НЬ ХҮРГЭХ БОЛОМЖТОЙ



БАГА СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГИЙН ЦОГЦОЛБОРЫН
ДАВУУ ТАЛ:





- ЦЭЦЭРЛЭГЭЭС СУРГУУЛЬД ЭЛСЭН ОРОХОД ОРЧНЫ ӨӨРЧЛӨЛТИЙН НӨЛӨӨ БАЙХГҮЙ

ДҮҮРГЭЭР

Барилгын тоогоор

Төсөвт өртгөөр /тэрбум.төг/


- Сүхбаатар дүүрэгт **300** ор/суудлын хүчин чадалтай **1** Цогцолборын барилга **2.8** тэрбум төгрөгөөр,
- Сонгинохайрхан дүүрэгт **960** ор/суудлын хүчин чадалтай **1** Цогцолборын барилга **13.0** тэрбум төгрөгөөр,
- Налайх дүүрэгт **280** ор/суудлын хүчин чадалтай **1** Цогцолборын барилга **5.0** тэрбум төгрөгөөр,
- Хан-Уул дүүрэгт **280** ор/суудлын хүчин чадалтай **1** Цогцолборын барилга **3.5** тэрбум төгрөгөөр,
- Баянзүрх дүүрэгт **560** ор/суудлын хүчин чадалтай **2** Цогцолборын барилга **8.8** тэрбум төгрөгөөр,
- Чингэлтэй дүүрэгт **480** ор/суудлын хүчин чадалтай **2** Цогцолборын барилга **7.0** тэрбум төгрөгөөр барьсан байна.




3.4 “БУСАД БАРИЛГА БАЙГУУЛАМЖ”

2020-2023 онд нийслэлийн хэмжээнд нийт **23.0** тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй дараах /сургууль, цэцэрлэгийн барилгаас бусад/ төрлийн **13** барилгуудыг барьж ашиглалтад оруулсан байна. Үүнд:

- Сургуулийн спорт заалны **7** барилга **5.4** тэрбум төгрөгөөр
- Хүзүүвчний **2** барилга **0.5** тэрбум төгрөгөөр
- Дотуур байрны **2** барилга **13.1** тэрбум төгрөгөөр
- Албан бус боловсролын төвийн **1** барилга **4.0** тэрбум төгрөгөөр
- Гражний **1** барилга **33.3** сая төгрөгөөр




ОНООР



Дээрх барилгуудыг баригдсан оноор авч үзвэл:

2020 онд **5** барилга **3.6** тэрбум төгрөгөөр, 2021 онд **5** барилга **6.4** тэрбум төгрөгөөр, 2022 онд **2** барилга **12.9** тэрбум төгрөгөөр, 2023 онд **1** барилгыг **0.0** тэрбум төгрөгөөр барьсан байна.

ХӨРӨНГИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭР




Нийт ашиглалтад оруулсан бусад төрлийн барилгын нийт хөрөнгийг эх үүсвэрээр нь авч үзвэл:

- 96%-ийг Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар,
- 3%-ийг Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар,
- 1%-ийг Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар барьсан.

ДҮҮРГЭЭР


Сонгинохайрхан дүүрэгт **5** барилга **3.5** тэрбум төгрөг
Хан-Уул дүүрэгт **2** барилга **1.2** тэрбум төгрөг
Багануур дүүрэгт **2** барилга **5.0** тэрбум төгрөг
Баянгол дүүрэгт **1** барилга **0.1** тэрбум төгрөг
Чингэлтэй дүүрэгт **1** барилга **1.2** тэрбум төгрөг
Налайх дүүрэгт **1** барилга **11.7** тэрбум төгрөг
Сүхбаатар дүүрэгт **1** барилга **0.2** тэрбум төгрөг



Төсөвт өртгөөр /тэрбум.төг/

БҮЛЭГ 4. ИХ ЗАСВАР

4.1 “СУРГУУЛИЙН ЗАСВАР”



НИЙТ	АЖЛЫН ТОО	80
74 СУРГУУЛЬД	ТӨСӨВТ ӨРТӨГ	11.3 (тэрбум.төг)

Нийслэлийн төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын сурч боловсрох орчин нөхцөлийг хангах, сайжруулах үүднээс 2020-2023 онд нийт **74** сургуульд (давхардсан тоогоор) **11.3** тэрбум төгрөгийн **80** их засварын ажил хийсэн байна.




Нийт сургуулийн их засварын ажлыг хэрэгжсэн оноор нь авч үзвэл:

2020 онд **19** сургуульд **21** засварын ажлыг **2.4** тэрбум төгрөгөөр
 2021 онд **22** сургуульд **22** засварын ажлыг **2.0** тэрбум төгрөгөөр
 2022 онд **15** сургуульд **17** засварын ажлыг **3.3** тэрбум төгрөгөөр
 2023 онд **18** сургуульд **20** засварын ажлыг **3.6** тэрбум төгрөгөөр

Нийт сургуулиудад хийгдсэн засварын ажлын тоог дүүргээр авч үзвэл:

БЗД-ийн **11** сургуульд **14** засварын ажил
 ЧД-ийн **10** сургуульд **12** засварын ажил
 ХУД-ийн **10** сургуульд **12** засварын ажил
 СХД-ийн **10** сургуульд **10** засварын ажил
 БГД-ийн **9** сургуульд **13** засварын ажил
 СБД-ийн **8** сургуульд **10** засварын ажил
 НД-ийн **3** сургуульд **4** засварын ажил
 БНД-ийн **2** сургуульд **3** засварын ажил
 БХД-ийн **1** сургуульд **2** засварын ажил

Их засвар хийгдсэн сургуулийн тоо
 Их засварын ажлын тоо





ЗАСВАРЫН АЖИЛ ТӨРЛӨӨР




ЗАСВАРЫН АЖИЛ ТӨСӨВТ ӨРТГИЙН БҮЛГЭЭР

Засварын ажил төсөвт өртгийн бүлгээр

0-100 сая
100-200 сая
200-300 сая
301-400 сая
401-500 сая
501-1000 сая
2001-3000 сая


Ажлын тоо




ҮР ДҮН



Нийслэлийн төрийн өмчийн сургуулиудад 2020-2023 онд хийсэн их засвар шинэчлэлтийн ажлын үр дүнд давхардсан тоогоор **165006** сурагч, **10238** багш ажилчдын сурч, ажиллах орчин нөхцөл сайжирч барилга ашиглалтын хугацаа уртасгахаас гадна сурагчдын сурлага болон багш ажилчдын бүтээмжид эергээр нөлөөлсөн байна.






Нийслэлийн бяцхан иргэдийн ая тухтай сурч хүмүүжих орчин нөхцөлийг хангах, сайжруулах үүднээс 2020-2023 онд нийслэлийн төрийн өмчийн **97** цэцэрлэгт **12.9** тэрбум төгрөгийн **101** их засварын ажил хийж гүйцэтгэсэн байна.

4.2 “ЦЭЦЭРЛЭГИЙН ЗАСВАР”

НИЙТ	АЖЛЫН ТОО	101
97	ТӨСӨВТ ӨРТӨГ	12.9 (тэрбум.төг)
ЦЭЦЭРЛЭГТ		



■ Их засвар хийгдсэн цэцэрлэгийн тоо
■ Их засварын ажлын тоо



Нийт цэцэрлэгийн их засварын ажлыг хэрэгжсэн оноор нь авч үзвэл:

2020 онд **25** цэцэрлэгт **25** засварын ажлыг **3.0** тэрбум төгрөгөөр
2021 онд **20** цэцэрлэгт **21** засварын ажлыг **2.3** тэрбум төгрөгөөр
2022 онд **26** цэцэрлэгт **27** засварын ажлыг **2.9** тэрбум төгрөгөөр
2023 онд **26** цэцэрлэгт **28** засварын ажлыг **4.7** тэрбум төгрөгөөр

Нийт цэцэрлэгүүдэд хийгдсэн засварын ажлын тоог дүүргээр авч үзвэл:

СХД-ийн **17** цэцэрлэгт **23** засварын ажил
БГД-ийн **17** цэцэрлэгт **20** засварын ажил
БЗД-ийн **15** цэцэрлэгт **18** засварын ажил
ХУД-ийн **11** цэцэрлэгт **14** засварын ажил
ЧД-ийн **9** цэцэрлэгт **9** засварын ажил
НД-ийн **6** цэцэрлэгт **6** засварын ажил
БНД-ийн **5** цэцэрлэгт **5** засварын ажил
СБД-ийн **3** цэцэрлэгт **5** засварын ажил
БХД-ийн **1** цэцэрлэгт **1** засварын ажил

■ Их засвар хийгдсэн цэцэрлэгийн тоо
■ Их засварын ажлын тоо





ЗАСВАРЫН АЖИЛ ТӨРЛӨӨР




ЗАСВАРЫН АЖИЛ ТӨСӨВТ ӨРТГИЙН БҮЛГЭЭР

Засварын ажил төсөвт өртгийн бүлгээр

0-100 сая
100-200 сая
201-300 сая
301-400 сая
401-500 сая
501-1000 сая
2001-3000 сая

Ажлын тоо



ҮР ДҮН



Нийслэлийн төрийн өмчийн цэцэрлэгүүдэд 2020-2023 онд хийсэн их засваршинэчлэлтийн ажлын үр дүнд давхардсан тоогоор **32311** хүүхэд, **3785** багш ажилчдын сурч, ажиллах орчин нөхцөл сайжирч барилга ашиглалтын хугацаа уртассан байна.




БҮЛЭГ 5. ТОХИЖИЛТ

5.1 “СУРГУУЛИЙН ТОХИЖИЛТ”



НИЙТ	АЖЛЫН ТОО	51
48 СУРГУУЛЬД	ТӨСӨВТ ӨРТӨГ	6.1 (тэрбум.төг)

Нийслэлийн төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулиудын гадаад дотоод орчин нөхцөлийг сайжруулах үүднээс 2020-2023 онд нийт **48** сургуульд **6.1** тэрбум төгрөгийн **51** тохижилтын ажил хийсэн байна.



Нийт сургуулийн тохижилтын ажлыг хэрэгжсэн оноор нь авч үзвэл:

2020 онд **10** сургуульд **10** тохижилтын ажлыг **1.4** тэрбум төгрөгөөр
2021 онд **4** сургуульд **4** тохижилтын ажлыг **0.6** тэрбум төгрөгөөр
2022 онд **4** сургуульд **4** тохижилтын ажлыг **0.4** тэрбум төгрөгөөр
2023 онд **30** сургуульд **33** тохижилтын ажлыг **3.7** тэрбум төгрөгөөр хийсэн байна.


Нийт сургуулиудад хийгдсэн тохижилтын ажлын тоог дүүргээр авч үзвэл:

ЧД-н **15** сургуульд **19** тохижилтын ажил
ХУД-н **8** сургуульд **11** тохижилтын ажил
БЗД-н **6** сургуульд **6** тохижилтын ажил
СБД-н **5** сургуульд **5** тохижилтын ажил
БГД-н **4** сургуульд **4** тохижилтын ажил
СХД-н **4** сургуульд **4** тохижилтын ажил
БНД-н **1** сургуульд **1** тохижилтын ажил
БХД-н **1** сургуульд **1** тохижилтын ажил






ТОХИЖИЛТЫН АЖИЛ ТӨРЛӨӨР



ТОХИЖИЛТЫН АЖИЛ ТӨСӨВТ ӨРТГИЙН БҮЛГЭЭР



ҮР ДҮН



2020-2023 онд төрийн өмчийн **48** сургуулиудад гадаад, дотоод тохижилтын ажлыг хийснээр давхардсан тоогоор **109232** сурагч, **4805** багш ажилчдын сурч, ажиллах орчин нөхцөл сайжирч сурагчдын сурлага болон багш ажилчдын ажлын бүтээмжид эергээр нөлөөлсөн байна.



5.2 “ЦЭЦЭРЛЭГИЙН ТОХИЖИЛТ”



НИЙТ	АЖЛЫН ТОО	28
28 ЦЭЦЭРЛЭГТ	ТӨСӨВТ ӨРТӨГ	1.8 (тэрбум.төг)

Нийслэлийн төрийн өмчийн цэцэрлэгүүдийн гадаад дотоод орчин нөхцөлийг сайжруулах үүднээс 2020-2023 онд **28** цэцэрлэгт **1.8** тэрбум төгрөгийн **28** тохижилтын ажил хийсэн байна.




Нийт цэцэрлэгийн тохижилтын ажлыг хэрэгжсэн оноор нь авч үзвэл:

2020 онд **9** цэцэрлэгт **9** тохижилтын ажлыг **0.7** тэрбум төгрөгөөр
 2021 онд **6** цэцэрлэгт **6** тохижилтын ажлыг **0.4** тэрбум төгрөгөөр
 2022 онд **5** цэцэрлэгт **5** тохижилтын ажлыг **0.6** тэрбум төгрөгөөр
 2023 онд **8** цэцэрлэгт **8** тохижилтын ажлыг **0.2** тэрбум төгрөгөөр


Нийт цэцэрлэгүүдэд хийгдсэн тохижилтын ажлын тоог дүүргээр авч үзвэл:

ХУД-н **10** цэцэрлэгт **10** тохижилтын ажил
 БЗД-н **6** цэцэрлэгт **6** тохижилтын ажил
 ЧД-н **4** цэцэрлэгт **4** тохижилтын ажил
 БГД-ийн **4** цэцэрлэгт **4** тохижилтын ажил
 СХД-ийн **3** цэцэрлэгт **4** тохижилтын ажил





ТОХИЖИЛТЫН АЖИЛ ТӨРЛӨӨР



ТОХИЖИЛТЫН АЖИЛ ТӨСӨВТ ӨРТГИЙН БҮЛГЭЭР



ҮР ДҮН



2020-2023 онд төрийн өмчийн 28 цэцэрлэгүүдэд гадаад, дотоод тохижилтын ажлыг хийснээр давхардсан тоогоор 9233 хүүхэд, 830 багш ажилчдын сурч, ажиллах орчин нөхцөл сайжирсан байна.



БҮЛЭГ 6. ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

6.1 “СУРГУУЛИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ”




НИЙТ
58
СУРГУУЛЬД

65 ТОНОГ
ТӨХӨӨРӨМЖ

3.1 ТЭРБУМ
ТӨГРӨГ

Нийслэлийн төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулиудын анги танхим сургалтын орчин нөхцөлийг сайжруулах үүднээс 2020-2023 онд **58** сургуульд **65** тоног төхөөрөмжийн ажлын худалдан авалтад нийт **3.1** тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна.




Нийт сургуулиудад хийгдсэн тоног төхөөрөмжийн ажлын тоог хэрэгжсэн оноор нь авч үзвэл:

2020 онд **11** тоног төхөөрөмжийн ажилд **0.3** тэрбум төгрөг
 2021 онд **5** тоног төхөөрөмжийн ажилд **0.2** тэрбум төгрөг
 2022 онд **16** тоног төхөөрөмжийн ажилд **0.6** тэрбум төгрөг
 2023 онд **33** тоног төхөөрөмжийн ажилд **2.0** тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

Нийт сургуулиудад хийгдсэн тоног төхөөрөмжийн ажлын тоог дүүргээр авч үзвэл:

БЗД-н **6** сургуульд **6** ажил **0.2** тэр.төг
 ХУД-н **8** сургуульд **11** ажил **0.5** тэр.төг
 БГД-н **10** сургуульд **16** ажил **0.4** тэр.төг
 СБД-н **10** сургуульд **17** ажил **0.6** тэр.төг
 СХД-н **15** сургуульд **15** ажил **1.4** тэр.төг



6.2 “ЦЭЦЭРЛЭГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ”




НИЙТ
210
ЦЭЦЭРЛЭГТ

344 ТОНОГ
ТӨХӨӨРӨМЖ

9.7 ТЭРБУМ
ТӨГРӨГ

Нийслэлийн төрийн өмчийн цэцэрлэгүүдийн анги танхим сургалтын орчин нөхцөлийг сайжруулах үүднээс 2020-2023 онд **210** цэцэрлэгт **344** тоног төхөөрөмжийн ажлын худалдан авалтад нийт **9.7** тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна.




Нийт цэцэрлэгүүдэд хийгдсэн тоног төхөөрөмжийн ажлын тоог хэрэгжсэн оноор нь авч үзвэл:

2020 онд **10** тоног төхөөрөмжийн ажилд **0.2** тэрбум төгрөг
2021 онд **2** тоног төхөөрөмжийн ажилд **0.3** тэрбум төгрөг
2022 онд **148** тоног төхөөрөмжийн ажилд **4.5** тэрбум төгрөг
2023 онд **184** тоног төхөөрөмжийн ажилд **4.5** тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

Нийт цэцэрлэгүүдэд хийгдсэн тоног төхөөрөмжийн ажлын тоог дүүргээр авч үзвэл:

БНД-н **6** цэцэрлэгт **6** ажил **0.1** тэр.төг
ЧД-н **5** цэцэрлэгт **11** ажил **0.4** тэр.төг
НД-н **9** цэцэрлэгт **17** ажил **0.4** тэр.төг
СБД-н **9** цэцэрлэгт **20** ажил **0.5** тэр.төг
БГД-н **13** цэцэрлэгт **41** ажил **0.9** тэр.төг
ХУД-н **19** цэцэрлэгт **65** ажил **1.8** тэр.төг
БЗД-н **38** цэцэрлэгт **100** ажил **2.5** тэр.төг
СХД-н **47** цэцэрлэгт **84** ажил **2.9** тэр.төг



БҮЛЭГ 7. ДҮҮРГЭЭР



БАЯНГОЛ
ДҮҮРЭГ



7.1 “БАЯНГОЛ ДҮҮРЭГ”

2020-2023 онд Баянгол дүүргийн боловсролын салбарт нийт **54.2** тэрбум төгрөгөөр **116** хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын төсөл арга хэмжээ хийгдсэн байна



ТӨСӨЛ АРГА
ХЭМЖЭЭ

116


АЖИЛ

НИЙТ ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТ

54.2


ТЭРБУМ.ТӨГ

АЖЛЫН ТӨРЛӨӨР



	АЖИЛ		ТӨСӨВТ ӨРТӨГ	
	ТОО	ХУВЬ	САЯ ТӨГ	ХУВЬ
БАРИЛГА УГСРАЛТ	18	16%	49,561.5	91%
ИХ ЗАСВАР	33	28%	2,972.0	5%
ТОХИЖИЛТ	8	7%	378.7	1%
ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ	57	49%	1,288.0	3%


АЖЛЫН ТӨРӨЛ, ОН, ТӨСӨВТ ӨРТГӨӨР /сая.төг/



Баянгол дүүрэгт нийт хийгдсэн хөрөнгө оруулалтыг хэрэгжсэн оноор нь авч үзвэл:

2020 онд **28** ажил **6,883.1** сая төгрөгөөр, 2021 онд **11** ажил **17,533.3** сая төгрөгөөр, 2022 онд **42** ажил **12,969.8** сая төгрөгөөр, 2023 онд **35** ажил **16,814.0** тэрбум төгрөгөөр тус тус хийгдсэн байна.

“БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ОНЦЛОХ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТУУД”





БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ



7.2 “БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ”

ТӨСӨЛ АРГА
ХЭМЖЭЭ

195

АЖИЛ

НИЙТ ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТ


150.1

ТЭРБУМ.ТӨГ

2020-2023 онд Баянзүрх дүүргийн боловсролын салбарт нийт **150.1** тэрбум төгрөгөөр **195** хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын төсөл арга хэмжээ хийгдсэн байна.




АЖЛЫН ТӨРЛӨӨР



	АЖИЛ		ТӨСӨВТ ӨРТӨГ	
	ТОО	ХУВЬ	САЯ ТӨГ	ХУВЬ
БАРИЛГА УГСРАЛТ	45	23%	138,081.9	91%
ИХ ЗАСВАР	32	16%	8,697.2	6%
ТОХИЖИЛТ	12	6%	556.1	1%
ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ	106	55%	2,721.3	2%


АЖЛЫН ТӨРӨЛ, ОН, ТӨСӨВТ ӨРТГӨӨР /сая.төг/



Баянзүрх дүүрэгт нийт хийгдсэн хөрөнгө оруулалтыг хэрэгжсэн оноор нь авч үзвэл:

2020 онд **24** ажил **51,923.8** сая төгрөгөөр, 2021 онд **22** ажил **18,235.8** сая төгрөгөөр, 2022 онд **45** ажил **20,382.5** сая төгрөгөөр, 2023 онд **104** ажил **59,514.3** сая төгрөгөөр тус тус хийгдсэн байна.

“БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ОНЦЛОХ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТУУД”





СҮХБААТАР ДҮҮРЭГ



7.3 “СҮХБААТАР ДҮҮРЭГ”

ТӨСӨЛ АРГА
ХЭМЖЭЭ

75

АЖИЛ

НИЙТ ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТ


40.7

ТЭРБУМ.ТӨГ

2020-2023 онд Сүхбаатар дүүргийн боловсролын салбарт нийт **40.7** тэрбум төгрөгөөр **75** хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын төсөл арга хэмжээ хийгдсэн байна.




АЖЛЫН ТӨРЛӨӨР




	АЖИЛ		ТӨСӨВТ ӨРТӨГ	
	ТОО	ХУВЬ	САЯ ТӨГ	ХУВЬ
БАРИЛГА УГСРАЛТ	13	17%	37,118.8	91%
ИХ ЗАСВАР	20	27%	1,605.0	4%
ТОХИЖИЛТ	5	7%	904.5	2%
ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ	37	49%	1,107.5	3%

АЖЛЫН ТӨРӨЛ, ОН, ТӨСӨВТ ӨРТГӨӨР /сая.төг/



Сүхбаатар дүүрэгт нийт хийгдсэн хөрөнгө оруулалтыг хэрэгжсэн оноор нь авч үзвэл:

2020 онд **15** ажил **3,440.8** сая төгрөгөөр, 2021 онд **11** ажил **10,257.4** сая төгрөгөөр, 2022 онд **11** ажил **8,669.6** сая төгрөгөөр, 2023 онд **38** ажил **18,368.0** сая төгрөгөөр тус тус хийгдсэн байна.

“СҮХБААТАР ДҮҮРГИЙН ОНЦЛОХ БҮТЭЭН
БАЙГУУЛАЛТУУД”



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ



7.4 “СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ”

ТӨСӨЛ АРГА
ХЭМЖЭЭ

177

АЖИЛ

НИЙТ ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТ

118.7

ТЭРБУМ.ТӨГ

2020-2023 онд Сонгинохайрхан дүүргийн боловсролын салбарт нийт **118.7** тэрбум төгрөгөөр **177** хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын төсөл арга хэмжээ хийгдсэн байна.




АЖЛЫН ТӨРЛӨӨР



	АЖИЛ		ТӨСӨВТ ӨРТӨГ	
	ТОО	ХУВЬ	САЯ ТӨГ	ХУВЬ
БАРИЛГА УГСРАЛТ	37	21%	108,957.7	92%
ИХ ЗАСВАР	33	19%	4,351.9	4%
ТОХИЖИЛТ	8	4%	1,150.3	1%
ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ	99	56%	4,287.2	3%

АЖЛЫН ТӨРӨЛ, ОН, ТӨСӨВТ ӨРТГӨӨР /сая.төг/



Сонгинохайрхан дүүрэгт нийт хийгдсэн хөрөнгө оруулалтыг хэрэгжсэн оноор нь авч үзвэл:

2020 онд **26** ажил **46,086.2** сая төгрөгөөр, 2021 онд **11** ажил **20,861.6** сая төгрөгөөр, 2022 онд **57** ажил **21,494.9** сая төгрөгөөр, 2023 онд **83** ажил **30,304.3** сая төгрөгөөр тус тус хийгдсэн байна.

“СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ОНЦЛОХ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТУУД”





ХАН-УУЛ ДҮҮРЭГ



7.5 “ХАН-УУЛ ДҮҮРЭГ”

ТӨСӨЛ АРГА
ХЭМЖЭЭ

152

АЖИЛ

НИЙТ ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТ


105.7

ТЭРБУМ.ТӨГ

2020-2023 онд Хан-Уул дүүргийн боловсролын салбарт нийт **105.7** тэрбум төгрөгөөр **152** хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын төсөл арга хэмжээ хийгдсэн байна.




АЖЛЫН ТӨРЛӨӨР



	АЖИЛ		ТӨСӨВТ ӨРТӨГ	
	ТОО	ХУВЬ	САЯ ТӨГ	ХУВЬ
БАРИЛГА УГСРАЛТ	29	25%	98,574.7	93%
ИХ ЗАСВАР	26	18%	3,720.2	4%
ТОХИЖИЛТ	21	4%	1,146.0	1%
ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ	76	53%	2,320.5	2%

АЖЛЫН ТӨРӨЛ, ОН, ТӨСӨВТ ӨРТГӨӨР /сая.төг/



Хан-Уул дүүрэгт нийт хийгдсэн хөрөнгө оруулалтыг хэрэгжсэн оноор нь авч үзвэл:

2020 онд **17** ажил **9,896.3** сая төгрөгөөр, 2021 онд **17** ажил **33,745.2** сая төгрөгөөр, 2022 онд **64** ажил **30,035.8** сая төгрөгөөр, 2023 онд **54** ажил **32,084.2** сая төгрөгөөр тус тус хийгдсэн байна.

“ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ОНЦЛОХ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТУУД”





ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ



7.6 “ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ”

ТӨСӨЛ АРГА
ХЭМЖЭЭ

68

АЖИЛ

НИЙТ ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТ

48.3

ТЭРБУМ.ТӨГ

2020-2023 онд Чингэлтэй дүүргийн боловсролын салбарт нийт **48.3** тэрбум төгрөгөөр **68** хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын төсөл арга хэмжээ хийгдсэн байна.




АЖЛЫН ТӨРЛӨӨР



	АЖИЛ		ТӨСӨВТ ӨРТӨГ	
	ТОО	ХУВЬ	САЯ ТӨГ	ХУВЬ
БАРИЛГА УГСРАЛТ	13	19%	43,318.6	90%
ИХ ЗАСВАР	21	31%	1,591.7	3%
ТОХИЖИЛТ	23	33%	2,967.9	6%
ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ	11	17%	387.9	1%

АЖЛЫН ТӨРӨЛ, ОН, ТӨСӨВТ ӨРТГӨӨР /сая.төг/



Чингэлтэй дүүрэгт нийт хийгдсэн хөрөнгө оруулалтыг хэрэгжсэн оноор нь авч үзвэл:

2020 онд **8** ажил **20,892.8** сая төгрөгөөр, 2021 онд **16** ажил **13,180.2** сая төгрөгөөр, 2022 онд **13** ажил **4,932.2** сая төгрөгөөр, 2023 онд **31** ажил **9,261.0** тэрбум төгрөгөөр тус тус хийгдсэн байна.

“ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ОНЦЛОХ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТУУД”





НАЛАЙХ ДҮҮРЭГ



7.7 “НАЛАЙХ ДҮҮРЭГ”

ТӨСӨЛ АРГА
ХЭМЖЭЭ

36

АЖИЛ

НИЙТ ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТ

35.8

ТЭРБУМ.ТӨГ

2020-2023 онд Налайх дүүргийн боловсролын салбарт нийт **35.8** тэрбум төгрөгөөр **36** хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын төсөл арга хэмжээ хийгдсэн байна.




АЖЛЫН ТӨРЛӨӨР



	АЖИЛ		ТӨСӨВТ ӨРТӨГ	
	ТОО	ХУВЬ	САЯ ТӨГ	ХУВЬ
БАРИЛГА УГСРАЛТ	9	25%	34,933.0	98%
ИХ ЗАСВАР	10	28%	459.3	1%
ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ	17	47%	419.5	1%

АЖЛЫН ТӨРӨЛ, ОН, ТӨСӨВТ ӨРТГӨӨР /сая.төг/



Налайх дүүрэгт нийт хийгдсэн хөрөнгө оруулалтыг хэрэгжсэн оноор нь авч үзвэл:

2020 онд **4** ажил **4,659.5** сая төгрөгөөр, 2021 онд **4** ажил **1,409.7** сая төгрөгөөр, 2022 онд **19** ажил **12,268.0** сая төгрөгөөр, 2023 онд **9** ажил **17,474.6** сая төгрөгөөр тус тус хийгдсэн байна.

“НАЛАЙХ ДҮҮРГИЙН ОНЦЛОХ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ”





БАГАНУУР ДҮҮРЭГ



7.8 “БАГАНУУР ДҮҮРЭГ”

ТӨСӨЛ АРГА
ХЭМЖЭЭ

18

АЖИЛ

НИЙТ ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТ

8.4

ТЭРБУМ.ТӨГ

2020-2023 онд Багануур дүүргийн боловсролын салбарт нийт **8.4** тэрбум төгрөгөөр **18** хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын төсөл арга хэмжээ хийгдсэн байна.




АЖЛЫН ТӨРЛӨӨР



	АЖИЛ		ТӨСӨВТ ӨРТӨГ	
	ТОО	ХУВЬ	САЯ ТӨГ	ХУВЬ
БАРИЛГА УГСРАЛТ	3	17%	6,668.2	80%
ИХ ЗАСВАР	8	44%	1,320.9	16%
ТОХИЖИЛТ	1	6%	274.5	3%
ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ	6	33%	90.0	1%

АЖЛЫН ТӨРӨЛ, ОН, ТӨСӨВТ ӨРТГӨӨР /сая.төг/



Багануур дүүрэгт нийт хийгдсэн хөрөнгө оруулалтыг хэрэгжсэн оноор нь авч үзвэл:

2020 онд **5** ажил **1,857.3** сая төгрөгөөр, 2021 онд **6** ажил **6,047.4** сая төгрөгөөр, 2022 онд **1** ажил **358.9** сая төгрөгөөр, 2023 онд **6** ажил **90.0** сая төгрөгөөр тус тус хийгдсэн байна.

“БАГАНУУР ДҮҮРГИЙН ОНЦЛОХ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТУУД”





БАГАХАНГАЙ ДҮҮРЭГ



7.9 “БАГАХАНГАЙ ДҮҮРЭГ”

ТӨСӨЛ АРГА
ХЭМЖЭЭ

4

АЖИЛ

НИЙТ ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТ

615.7

САЯ ТӨГРӨГ

2020-2023 онд Налайх дүүргийн боловсролын салбарт нийт **615.7** сая төгрөгөөр **4** хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын төсөл арга хэмжээ хийгдсэн байна.




АЖЛЫН ТӨРЛӨӨР



	АЖИЛ		ТӨСӨВТ ӨРТӨГ	
	ТОО	ХУВЬ	САЯ ТӨГ	ХУВЬ
ИХ ЗАСВАР	3	75%	135.7	22%
ТОХИЖИЛТ	1	25%	479.9	78%

АЖЛЫН ТӨРӨЛ, ОН, ТӨСӨВТ ӨРТГӨӨР /сая.төг/



Багахангай дүүрэгт нийт хийгдсэн хөрөнгө оруулалтыг хэрэгжсэн оноор нь авч үзвэл :

2020 онд **3** ажил **545.9** сая төгрөгөөр, 2021 онд **1** ажил **69.8** сая төгрөгөөр тус тус хийгдсэн байна.



“БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ОНЦЛОХ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ”



ХАВСРАЛТ

2020-2023 ОНД БАРЬЖ АШИГЛАЛТАД ОРУУЛСАН СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГИЙН БАРИЛГА

№	Хэрэгжсэн он	Төсөл, арга хэмжээний нэр	Сургууль, цэцэрлэгийн дугаар	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Хэмжих нэгж	Хүчин чадал
БАЯНГОЛ ДҮҮРЭГ						
1	2020	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 240 ор /Баянгол дүүрэг, 2 дугаар хороо, 66 дугаар цэцэрлэг/	66-р цэцэрлэг	УТХО	ор	240
2	2020	Цэцэрлэгийн барилга худалдан авах /БГД, 1 дүгээр хороо, Алтай хотхон/	295-р цэцэрлэг	НТХО	ор	150
3	2020	114-р цэцэрлэгийн өргөтгөл, 6-р хороо	114-р цэцэрлэг	УТХО	ор	150
4	2021	Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй Цэцэрлэгийн барилга, 240 ор /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 21 дүгээр хороо/	278-р цэцэрлэг	УТХО	ор	240
5	2021	Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй Сургуулийн барилга, 640 суудал /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 9 дүгээр хороо/	146-р сургууль	УТХО	суудал	640
6	2021	Сургуулийн барилга буулгаж, шинээр барих, 640 суудал /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 19 дүгээр сургууль/	19-р сургууль	УТХО	суудал	640
7	2021	30-р цэцэрлэгийг буулгаж барих, 11-р хороо	30-р цэцэрлэг	УТХО	ор	240
8	2021	Баянгол дүүрэг, 4-р хороо, 164-р цэцэрлэгийн өргөтгөл	164-р цэцэрлэг	ГАДААДЫН ЗЭЭЛ ТУСЛАМЖ	ор	150
9	2022	Орон сууцны 1 давхар, 50 ор (Баянгол дүүрэг, 26 дугаар хороо)	100-р цэцэрлэг	НТХО	ор	50
10	2022	Орон сууцны 1 давхар, 75 ор (Баянгол дүүрэг, 5 дугаар хороо)	114-р цэцэрлэг	НТХО	ор	75
11	2022	13-р цэцэрлэгийг буулгаж барих, 18-р хороо	13-р цэцэрлэг	УТХО	ор	240
12	2022	Баянгол дүүрэг, 51 дүгээр сургуулийн өргөтгөл	51-р сургууль	ГАДААДЫН ЗЭЭЛ ТУСЛАМЖ	суудал	320
13	2022	Цэцэрлэгийн барилга худалдан авах, 300 ор /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 24 дүгээр хороо/ 309-р цэцэрлэг	309-р цэцэрлэг	УТХО	ор	300
14	2023	Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй Сургуулийн барилгын өргөтгөл, 640 суудал /Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, Эрдмийн 70 дугаар сургуулийн хүүхэд зөөврийн 2 автобусны гражын барилга /БГД, 18 дугаар хороо/	Эрдмийн өргөө цогцолбор сургууль	УТХО	суудал	640
15	2023	164 дүгээр цэцэрлэгийн дэргэд Монгол өв уламжлал, ёс заншлын өргөө, 100 ор (Баянгол дүүрэг, 4 дүгээр хороо)	70-р сургууль	УТХО	м2	93
16	2023	164 дүгээр цэцэрлэгийн дэргэд Монгол өв уламжлал, ёс заншлын өргөө, 100 ор (Баянгол дүүрэг, 4 дүгээр хороо)	164-р цэцэрлэг	НТХО	ор	100
17	2023	34-р цэцэрлэгийг буулгаж барих, 20-р хороо	34-р цэцэрлэг	УТХО	ор	240
18	2023	Сэтгэмж сургуулийн барилга /46 - р сургууль/, 11-р хороо	46-р сургууль	УТХО	суудал	640
БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ						
1	2020	Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй Сургуулийн барилгын өргөтгөл, 640 суудал /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, Амгалан цогцолбор сургууль/	Амгалан сургууль	УТХО	суудал	640

№	Хэрэгжсэн он	Төсөл, арга хэмжээний нэр	Сургууль, цэцэрлэгийн дугаар	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Хэмжих нэгж	Хүчин чадал
2	2020	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 22 дугаар хороо/ Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй	257-р цэцэрлэг	УТХО	ор	100
3	2020	Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй цэцэрлэгийн барилга 100 ор /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 1 дүгээр хороо/	59-р цэцэрлэг	УТХО	ор	100
4	2020	Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй Цэцэрлэгийн барилга, 240 ор /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 10 дугаар хороо Цагдаагийн хотхон/	296-р цэцэрлэг	УТХО	ор	240
5	2020	Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй Цэцэрлэгийн барилга, 240 ор /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 8 дугаар хороо, Баганат хороолол/	289-р цэцэрлэг	УТХО	ор	240
6	2020	Цэцэрлэгийн барилга худалдан авах 100 ор /БЗД, 25 дугаар хороо/	256-р цэцэрлэг	НТХО	ор	100
7	2020	Сургуулийн барилга худалдан авах 640 суудал /БЗД, 22 дугаар хороо/	155-р сургууль	НТХО	суудал	640
8	2020	10-р цэцэрлэгийг буулгаж барих, 3-р хороо	10-р цэцэрлэг	УТХО	ор	280
9	2020	Цэцэрлэгийн барилга, 22-р хороо, 257-р цэцэрлэг	257-р цэцэрлэг	УТХО	ор	100
